



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/124

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх “Мал эмнэлгийн үйлчилгээ ӨВХУСЗДТГ/201901019” барааг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи,
үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга

Б.Доржсэмбэ - Иргэний төлөөлөл (зөвшилцснөөр)

2. Дээрх барааг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж авахыг ажлын хэсэг (С.Самдан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/125

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 , 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн иргэн Дамдинпүрэвийн Ганбаатарын (ЙС72040917) эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 21 тоотод байрлах 0023335 тоот гэрчилгээний дугаартай, 6211000288 тоот нэгж талбарын дугаартай худалдаа үйлчилгээний зориулалттай 500 м² газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/126


Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн уулзалтын арга хэмжээний зардалд 620000 (зургаан зуун хорин мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.
2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/112-7

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хужирт сумын их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа нэр бүхий 2 оюутанг шагнаж урамшуулахад 60000 (жаран мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 24-ны өдрийн 107 дугаар
захирамжийн хавсралт

№	ОВОГ НЭР	АЛБАН ТУШААЛ	МӨНГӨН ДҮН
1	Нарантуяагийн Уранжаргал	оюутан	30000
2	Ганболдын Энхжин	оюутан	30000
НИЙТ			60000

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/128

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банк, Швейцарийн хөгжлийн агентлаг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс сумын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг суманд ирж ажилласантай холбогдуулан байр, хоолны зардалд 1414000 (нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Хужирт сум

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/129

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь
заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн иргэн Лэгшидийн Мэндбаярын (ЙС74041614)
эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 26 тоотод байрлах 0343575 тоот гэрчилгээний
дугаартай, 6211000314 тоот нэгж талбарын дугаартай худалдаа үйлчилгээний
зориулалттай 3786 м² газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж
үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын
улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/130

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар, БГД,12-р хороо, 6 бичил хороолол, хасбаатар гудамж, 24 байр, 27 тоотод оршин суугч Ж.Бямбасүрэн (ЙС68022011) нь өөрийн эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 21 тоотод байрлах 0166605 тоот гэрчилгээний дугаартай, 141910272 тоот нэгж талбарын дугаартай үүлчилгээний зориулалттай 500.0 м2 газрыг тус сумын 4 дүгээр баг Шивээт 3-20 тоот хаягт оршин суугч Базарсадын Доржсэмбэ (ЙС96112617) -ийн эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Б.Доржсэмбэ (ЙС96112617)-д худалдаа, үйлчилгээний зориулалтаар 46 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2008 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн "Газар эзэмшүүлэх тухай" 120 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/131

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дүгээр зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдсан нэр бүхий 4 иргэнд өвөлжөө хаваржааны доорхи газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хукирт сумын Засаг даргын 2019 оны
 10 дугаар сарын 27 нийгмийн 1/21 дугаар
 захирамжийн хавсралт

Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмших иргэдийн нэрсийн жагсаалт

Газар эзэмшигчийн		Эзэмшсэн газрын						
д/д	Эцэг /эх/- ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Багийн нэр, дугаар	Хаяг, байршил, газар зүйн нэр	Зориулалт	Хэмжээ /м²/	Газар зүйн солбицол
1	Гүржав	Чулуун	ЙС55110919	Шунхлай 5-р баг	Шар хадны мухарт	Өвөлжөө	700	5194116,879 326263,886
2	Сосорбурам	Баянмөнх	ЙС76080411	Дулаан 6-р баг	Нурамтын Улаан хад	Өвөлжөө	700	5193972,3 358605,5
3	Данзандорж	Жааханнэргүй	ЙС75040520	Бэрх 3-р баг	Ангал	Өвөлжөө	700	5198371,95 317666,95
4	Мягмар	Догсом	ЙС97010210	Бэрх 3-р баг	Зүлэгний Гурвалжин	Өвөлжөө	700	5206905,369 333509,707



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/132

Хужирт сум

2019 оны тодотгосон төсвийн хуваарь
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 13/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн байгууллагуудын төсвийн тодотгосон хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



Сумын засаг даргын 2019 оны 11 сарын 05 ны өдрийн
 9/184 др захирамжийн 1 д хавсралт

ИТХУРЛЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН 2019 ОНЫ ХУВААРИЛАЛТ

	Э/Засгийн ангилал код	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
80101	210101 Үндсэн цалин	41764.9	3087.0	3087.0	3087.0	6174.0	6174.0	4087.0	4088.1	1087.1	3087.0	4719.7	0.0
2102	Ажил олгогчоос НДШ төлөлт	5147.4	385.9	385.9	385.9	771.8	771.8	510.9	511.0	135.9	385.9	516.7	0.0
210201	Тэтгэврийн даатгал	3,275.6	245.6	245.6	245.6	491.1	491.1	325.1	325.2	86.5	245.6	351.4	-
210202	Тэтгэмжийн даатгал	374.4	28.1	28.1	28.1	56.1	56.1	37.2	37.2	9.9	28.1	41.3	-
210203	ҮОМШ өвчний даатгал	467.9	35.1	35.1	35.1	70.2	70.2	46.4	46.5	12.4	35.1	33.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	93.6	7.0	7.0	7.0	14.0	14.0	9.3	9.3	2.5	7.0	8.3	-
210205	Эрүүл мэндийн даатгал	935.9	70.2	70.2	70.2	140.3	140.3	92.9	92.9	24.7	70.2	82.7	-
210401	Бичиг хэрэг	751.3	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0	65.0	60.0	70.0	66.3
210402	тээвэр шатахуун	4586.4	1100.0	315.2	315.2	315.2	315.2	315.2	315.2	315.2	315.2	315.2	334.4
210403	шуудан холбоо,интернет	320.0	26.6	26.6	26.6	26.6	26.6	26.6	26.6	26.6	26.6	26.6	27.4
210404	ном хэвлэл	50.0		14.0		12.0				12.0			12.0
210503	нормын хувцас зөөлөн эдлэл	50.0	0.0			50.0							
210604	урсгал засвар	2100.0	1200.0	80.0		280.0		280.0			260.0		
210702	дотоод албан томилолт	1400.0	400.0	0.0	116.0	116.0	116.0	116.0	0.0	116.0	116.0	116.0	72.0
210801	Бусад нийтлэг АУТХураамж	1180.0		295.0		295.0				295.0			295.0
210804	тээврийн хэрэгсэлийн татвар	150.0			150.0								
210805	тээврийн хэрэгсэлийн оношлогоо	30.0			30.0								
210806	мэдээлэл технологийн үйлчилгээ	120.0		120.0									
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5000.0	450.0	450.0	450.0	400.0	400.0	450.0	0.0	400.0	400.0	400.0	800.0
Дүн		62650.0	6709.5	4474.7	4754.7	7913.6	8175.6	5845.7	5000.9	2452.8	4650.7	6164.2	1607.1
80825	210104 Урамшуулал	14434.2	990.4	990.4	990.4	990.4	990.4	990.4	990.3	990.3	990.4	3,540.0	990.4
2102	Ажил олгогчоос НДШ төлөлт	1703.7	123.8	123.8	123.8	123.8	123.8	123.8	123.8	123.8	123.8	341.9	123.8
210201	Тэтгэврийн даатгал	1,084.2	78.8	78.8	78.8	78.8	78.8	78.8	78.8	78.8	78.8	227.4	78.8
210202	Тэтгэмжийн даатгал	123.9	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	26.0	9.0
210203	ҮОМШ өвчний даатгал	154.9	11.3	11.3	11.3	11.3	11.3	11.3	11.3	11.3	11.3	25.3	11.3
210204	Ажилгүйдлийн даатгал	31.0	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.3	2.3	5.8	2.3
210205	Эрүүл мэндийн даатгал	309.8	22.5	22.5	22.5	22.5	22.5	22.5	22.5	22.5	22.5	57.4	22.5
Дүн		16137.9	1114.2	1114.2	1114.2	1114.2	1114.2	1114.2	1114.1	1114.1	1114.2	3881.9	1114.2
80802	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1540.0		400.0	0.0	400.0				370.0		0.0	370.0
Дүн		1540.0		400.0	0.0	400.0				370.0		0.0	370.0
82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	5320.0	360.0	610.0	360.0	610.0	610.0	360.0	360.0	610.0	360.0	360.0	610.0
Дүн		5320.0	360.0	610.0	360.0	610.0	610.0	360.0	360.0	610.0	360.0	360.0	610.0
Нийт дүн		85647.8	8183.7	6878.9	6374.9	9387.8	10299.8	7319.9	6475.0	4546.9	6124.9	10406.1	3701.3
350003	ОНОРлогын үлдэгдэл	17254.1	4090.0	360.0	360.0	660.0	660.0	360.0	360.0	660.0	360.0	8364.1	660.0
320001	Санхүүгийн дэмжлэг	68393.7	4093.7	5588.9	6218.9	6014.9	9027.8	6959.9	6115.0	3886.9	5764.9	2042.0	3041.3



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/135


Хужирт сум

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 08/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тамхины худалдаа эрхэлж буй Д.Энхбаатарын “Бор Хул” дэлгүүрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасугай.
2. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (Х.Түмэнбаяр), Мал эмнэлгийн Улсын Байцаагч (Б.Ичинхоролцэвэлмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/136

Хужирт сум

Насан туршийн боловсролын “Дүйцсэн
хөтөлбөр”-ийн сургалт явуулах тухай

Монгол Улсын Боловсрол, Соёл шинжлэх ухаан, спортын яамны сайдын 2018 оны А/168 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Боловсрол, соёлын газрын дүгнэлтийг үндэслэн сургууль завсардсан, Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй сургуулийн насны болон суурь, бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлтэй иргэдэд насан туршийн боловсролын “Дүйцсэн хөтөлбөр”-ийн сургалтыг зохион байгуулж явуулсугай.

2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллахыг Насан туршийн боловсролын арга зүйч (Б.Цэрэнноров)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн Насан туршийн боловсролын “Дүйцсэн хөтөлбөр”-ийн сургалт явуулах тухай А/176 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/137

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн Өвгөн жалгын 1 тоотод байрлах 358 м² газрыг Засаг даргын Тамгын газарт (РД:9045562) төмс, хүнсний ногоо болон малын тэжээл хадгалах зорьны зориулалтаар 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/138

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх төсөл, хөтөлбөрүүдийн төсвийн судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл -Засаг даргын орлогч

Гишүүд: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга

З.Цэцэгмаа- Байгаль орчны хяналтын Улсын
Байцаагч

Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга

Т.Энхжаргал- Хөдөлмөрийн ажилтан

С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи,
үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

2. Судалгааг үнэн зөв бодитой хийж Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/139

Хужирт сум


Урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2013 оны А/406 дугаар захирамжаар батлагдсан “Төсвийн ерөнхий болон шууд захирагч нарын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх” журам, 2019 оны “Шагнал, урамшуулал олгох, хариуцлага тооцох тухай” А/376 дугаар захирамжийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны төсөв санхүүгийн сахилга бат, хариуцлага, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг харгалзан Засаг даргын Тамгын газрын дарга, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, 1, 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч, Нягтлан бодогч нарын урамшууллын хэмжээг хавсралтаар тус тус баталсугай.


2. Урамшууллыг тогтоосон хэмжээгээр тухайн байгууллагын төсвөөс олгохыг дээрх байгууллагуудыг хариуцсан нягтлан бодогч нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны 11...
дүгээр сарын 13-ны өдрийн 1139 дугаар
захирамжийн хавсралт



№	Байгууллагын нэр	Шууд захирагч	Хэмжээ	Нягтлан бодогч, Төрийн сангийн мэргэжилтэн	Хэмжээ
1	Засаг даргын Тамгын газар	Д.Энхтүвшин	0,5 сар	Г.Оюунмандах	0,5 сар
2	Ерөнхий боловсролын сургууль	Т.Баярмөнх	1 сар	Ч.Оюунцэцэг	0,5 сар
3	Соёлын төв	О.Долгормаа	1 сар	Ч.Оюунцэцэг	1 сар
4	1 дүгээр цэцэрлэг	З.Оюунчимэг	1 сар	Л.Сувд-Эрдэнэ	0.5 сар
5	2 дугаар цэцэрлэг	Ш.Эрдэнэхорол	1 сар	Л.Сувд-Эрдэнэ	0.5 сар
6	Эрүүл мэндийн төв	Н.Баярцэцэг	0.5 сар	Б.Пүрэвжав	1 сар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 1170

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын төвийн гуу жалга засвар ӨВХУСЗДТГ/201901012" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Шижээ - "Хужирт эрдэс баялаг" ОНӨААТҮГ-ын дарга

Гишүүд: С.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

О.Алтанчимэг - Байгаль хамгаалагч

Б.Доржсэмбэ - Иргэний төлөөлөл (зөвшилцснөөр)

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Ж Шижээ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/141

Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2019 оны "Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" А/678 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч тархсан Өвөрмодот, Дулаан багийн 6000 га бэлчээрт энгийн механик биологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ханган сургалт зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл)-т үүрэг болгосугай.

3. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (З.Цэцэгмаа), ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг заавар журмын дагуу гаргаж 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хүнс, Хөдөө Аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Оюунгэрэл) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/172

Хужирт сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газрын даргын тушаалаар суманд 2 өдөр зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн зардалд 1425060 (нэг сая дөрвөн зуун хорин таван мянга жаран) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны
11. дугаар сарын 28-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

№	Зардлын төрөл	Өдөр	Нэгжийн тоо	Нэгж ноогдох мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Ор хоног	2	4	55000	440000
2	Хоол II/	3	4	7500	90000
3	Хоол III/	3	4	8500	102000
4	Хээрийн хүнс	2	1	168470	336940
5	Хулдаасан хэвлэл		8000	14,88	119040
6	Урамшуулал	1	5	40000	200000
7	Бичиг хэрэг	-	-	119080	119080
Бүгд					1425060

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/143

Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2006 оны “Газар өмчлүүлэх тухай” 17 дугаар захирамжийн хавсралтын 119 дугаарт байгаа 1 өрхийн нэр бүхий 3 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



Хужирт сумын Засаг даргын 2019 оны
 11... дүгээр сарын 21... ны өдрийн 11/11/13 дугаар
 захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Өрхийн дугаар	Д/д	Өмчлөгчийн						Газрын			
		Овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ /мян төг/
A	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
119	1	Боржигин	Санжаазав	Чулуунбат	5-р баг	ЙС73030117		2005.02.28	5-р баг	500	360000
	2	Боржигин	Чулуунбат	Түмэнхүслэн	5-р баг	ЙС02291108		17		0	0



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/1144

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 , 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Бэрх 3 дугаар багийн иргэн Л.Болормаагийн (ЙС79110527) эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 15 тоотод байрлах 000642985 тоот гэрчилгээний дугаартай, 6211000307 тоот нэгж талбарын дугаартай худалдаа үйлчилгээний зориулалттай 500 м² газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/145

Хужирт сум

Газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий 1 иргэнд аж ахуйн зориулалтаар хавсралтанд заасан хэмжээний газрыг өмчлүүлсүгэй.
2. Иргэнд өмчлүүлэх газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2019 оны
 ...11... дүгээр сарын 21-ний өдрийн 175 дугаар
 захирамжийн хавсралт

Газар өмчлүүлэх иргэдийн нэрсийн жагсаалт

Өмчлөгчийн					Газрын				
Д/д	Овог	Эцэг /эх/- ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй газар өмчлөгчийн гэрчилгээний дугаар	Байршил	Хэмжээ /м2/	Газрын үнэ мян.төг
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Хув	Дорж	Энхбаатар	5-р баг	Йс74012815	-	5-р баг Гуа- 66 тоот	1800	3600.0



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/176

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шивээт 4 дүгээр багийн нутагт орших "Амин хишиг" ХХК (3556816)-ийн эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 57 тоотод байрлах 000325904 тоот гэрчилгээний дугаартай, 6211003825 тоот нэгж талбарын дугаартай эмийн сангийн зориулалттай 852 м² газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/147

Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

“Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2005 оны “Газар өмчлүүлэх тухай” 88 дугаар захирамжийн хавсралтын 153 дугаарт байгаа 1 өрхийн нэр бүхий 2 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

Хужирт сумын Засаг даргын 2019 оны
 11 дүгээр сарын 21 -ны өдрийн 1117 дугаар
 захирамжийн хавсралт



Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

Д/д	Өмчлөгчийн						Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо	Газрын		
	Овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Оршин суугаа хаяг	Регистр	16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар		Байршил	Хамжээ /м2/	Газрын үнэ /мян.төг/
0	1	2	3	4	5	6	7	8	9	10
2	1	Диймаа	Жагзмаа	УБ.СХ Д	ЙС7204030 7		2008.01.31 15	4-р баг	250 0	180000 0



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/148

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Атар газар эзэмшиж, хөгжүүлсний 60 жилийн ой"-н медальний үнэ 154450 (нэг зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун тавин) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны
11 дугаар сарын 29-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

№	ОВОГ НЭР	ТОО, ШИРХЭГ	МӨНГӨН ДҮН
1	Медаль	10	15445
НИЙТ			154450

-oOo-



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/149

Хужирт сум

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний Г
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 , 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдсан нэр бүхий 7 иргэний худалдаа, үйлчилгээний зориулалтгаар эзэмшиж буй газрын эзэмших эрхийг тус бүр 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.
2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/150

Хужирт сум

Жилийн эцсийн мал тооллогын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн (г), Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 (в) дэх заалт, Засгийн газрын 2003 оны "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд: Комиссын дарга: Ж.Оюунгэрэл

Нарийн бичгийн дарга: Д.Уранчимэг

Гишүүд: Б.Ичинхоролцэвэлмаа

Засаг даргын орлогч

Санхүүгийн албаны дарга

Мал эмнэлгийн

Улсын Байцаагч

Хэсгийн төлөөлөгч

Э.Бямбацэрэн

Б.Пагамдулам

Д.Батбаян

Д.Галиндэв

Д.Батбаяр

Я.Осоржамаа

Ц.Амгалан

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга

3 дугаар багийн Засаг дарга

4 дугаар багийн Засаг дарга

5 дугаар багийн Засаг дарга

6 дугаар багийн Засаг дарга

2. Мал тооллогын ажлыг багуудад зохион байгуулах салбар комиссуудын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар, тээврийн хэрэгсэл, бензин шатахууны хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Жилийн эцсийн мал тооллогын ажлыг батлагдсан удирдамж, графикийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Ж.Оюунгэрэл), тооллогын нэгдсэн дүн мэдээг 2019 оны 12 дугаар сарын 20-ны дотор холбогдох газарт хүргүүлэхийг комиссын нарийн бичгийн дарга (Д.Уранчимэг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 22-ны өдрийн 140 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

Багуудад мал тооллогын ажил зохион байгуулах
комиссын бүрэлдэхүүн

I баг: / Өвөр модот /

Ахлагч: Б.Дэмбэрэл
Гишүүд: Б.Пагамдулам
Ш.Отгонбат

Ц.Батдэлгэр
Д.Жавзандолгор

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
1 дүгээр багийн Засаг дарга
1 дүгээр багийн иргэдийн Нийтийн
Хурлын дарга
Малын эмч
Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал
хариуцсан мэргэжилтэн

II баг: / Уужим / 1 дүгээр хэсэг

Ахлагч: Д.Батбаян
Гишүүд: Ч.Сонинбаяр
С.Самдан
Б.Алтанцэцэг

2 дугаар багийн Засаг дарга
Байгаль хамгаалагч
Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
Багийн эмч

2 дугаар хэсэг

Ахлагч: Д.Төмөр

Гишүүд: Т.Сундуйбаяр
Н.Хүрэлбаатар

О.Алтанчимэг

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Нарийн бичгийн дарга
Мал эмнэлгийн тархвар зүйч
2 дугаар багийн иргэдийн
Нийтийн Хурлын дарга
Байгаль хамгаалагч

III баг: / Бэрх / 1 дүгээр хэсэг

Ахлагч: Т.Даваадорж
Гишүүд: З.Цэцэгмаа
Х.Дагвасүрэн

3 дугаар багийн ИНХ-ын дарга
БОХУБайцаагч
“Монгол засвар” ХХК-ний сантехникч

2 дугаар хэсэг

Ахлагч: Т.Баярмөнх
Гишүүд: Д.Галиндэв
Б.Ичинхоролцэвэлмаа
Б.Саранцогт

Сумын Засаг дарга
3 дугаар багийн Засаг дарга
Мал эмнэлгийн Улсын Байцаагч
Багийн эмч

IV баг: / Шивээт /

Ахлагч: Д.Батбаяр
Гишүүд: Ж.Шижээ

Б.Цэрэннадмид
Ц.Нямдорж
Д.Мягмарсүрэн

